



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/162/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Утас: 99158257 Цахим хаяг: Tsoqjargalb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2024.02.22 № 36
танай _____-ны № _____-т

ХОТОНТ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОРЖДЭРЭМ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 1,272.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон
2. Цалингийн сангаас 1,600.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг тус тус зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус сумын түүхт 100 жилийн ой тохиосон байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн зардал өмнөх оноос 62.6 хувиар нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 үндсэн зорилтын хүрээнд 90 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын Засаг даргаас 92.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	645,000.00	1,382,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	645,000.00	1,382,000.00
35400	Хангамжийн материал	645,000.00	1,382,000.00
35410	Бичиг хэргийн материал	645,000.00	1,295,000.00
35420	Аж ахуйн материал	0.00	87,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,797,969.90	6,101,877.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,797,969.90	6,101,877.80
39200	Биет хөрөнгө	7,797,969.90	6,101,877.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	10,031,134.00	10,031,134.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,348,451.69	-5,785,525.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,696,580.00	4,696,580.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,581,292.41	-2,840,310.71
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,442,969.90	7,483,877.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,442,969.90	7,483,877.80
51	Засгийн газрын хувь оролцоо	8,442,969.90	7,483,877.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,234,000.00	2,234,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,234,000.00	2,234,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	6,133,705.86	5,174,613.76
51210	Өмнөх үеийн үр дүн	7,359,681.21	6,133,705.86
51220	Тайлант үеийн үр дүн	-1,225,975.35	-959,092.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,264.04	75,264.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,442,969.90	7,483,877.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	90,163,700.00	125,685,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,163,700.00	125,685,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,163,700.00	125,685,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,163,700.00	125,685,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	91,389,675.35	126,644,892.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,389,675.35	126,644,892.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,837,146.66	95,282,931.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,965,971.31	76,103,450.40
210101	Үндсэн цалин	40,861,588.53	58,137,318.19
210102	Нэмэгдэл	4,604,383.09	12,529,105.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	1,593,042.48
210104	Урамшуулал	1,499,999.69	3,843,984.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,115,600.00	8,915,527.90
210201	Тэтгэврийн даатгал	4,158,700.00	6,068,338.39
210202	Тэтгэмжийн даатгал	489,200.00	713,922.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	391,400.00	571,137.71
210204	Ажилгүйдлийн даатгал	172,465.31	134,284.50
210205	Эрүүл мэндийн даатгал	903,834.69	1,427,845.15

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	6,039,600.00	5,981,200.00
210401	Бичиг хэрэг	1,739,600.00	1,773,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,300,000.00	4,207,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,023,000.00	1,213,000.00
210604	Урсгал засвар	1,023,000.00	1,213,000.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	774,800.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	774,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,000.00	161,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	71,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,267,975.35	2,133,853.61
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,000.00	437,761.51
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,225,975.35	1,696,092.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,552,528.69	31,361,960.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,443,900.00	21,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,443,900.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,000,000.00	21,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,108,628.69	10,361,960.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,108,628.69	10,361,960.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,225,975.35	-959,092.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,225,975.35	-959,092.10

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	90,163,700.00	125,685,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,163,700.00	125,685,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	90,163,700.00	125,685,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	90,163,700.00	125,685,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,163,700.00	125,685,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,163,700.00	125,685,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,611,171.31	93,323,839.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,965,971.31	75,067,450.40
210101	Үндсэн цалин	40,861,589.93	51,705,979.49
210102	Нэмэгдэл	4,604,381.69	17,924,443.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	1,593,042.48
210104	Урамшуулал	1,499,999.69	3,843,984.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,115,600.00	8,915,527.90
210201	Тэтгэврийн даатгал	4,158,700.00	6,068,338.39
210202	Тэтгэмжийн даатгал	489,200.00	713,922.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	391,400.00	571,137.71
210204	Ажилгүйдлийн даатгал	172,465.31	134,284.50
210205	Эрүүл мэндийн даатгал	903,834.69	1,427,845.15
2104	Хангамж, бараа материалын зардал	5,604,600.00	6,017,200.00
210401	Бичиг хэрэг	1,304,600.00	2,217,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,300,000.00	3,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,300,000.00

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210604	Урсгал засвар	1,000,000.00	1,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	774,800.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	774,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,000.00	161,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	71,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	1,087,761.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	1,087,761.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,552,528.69	32,361,960.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,443,900.00	22,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,443,900.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,000,000.00	22,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,108,628.69	10,361,960.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,108,628.69	10,361,960.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	7,359,681.21	9,668,945.25
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	7,359,681.21	9,668,945.25
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,225,975.35	-1,225,975.35
4	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	6,133,705.86	8,442,969.90
5	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	6,133,705.86	8,442,969.90
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	6,133,705.86	8,442,969.90
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-959,092.10	-959,092.10
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,234,000.00	75,264.04	5,174,613.76	7,483,877.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,685,800.00	115,323,839.81	10,361,960.19	91.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,685,800.00	115,323,839.81	10,361,960.19	91.76

Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,685,800.00	93,323,839.81	10,361,960.19	90.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,793,900.00	75,067,450.40	8,726,449.60	89.59
210101	Үндсэн цалин	83,793,900.00	51,705,979.49	32,087,920.51	61.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,474,200.00	8,915,527.90	1,558,672.10	85.12
210201	Тэтгэврийн даатгал	7,122,400.00	6,068,338.39	1,054,061.61	85.20
210202	Тэтгэмжийн даатгал	837,900.00	713,922.15	123,977.85	85.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	670,400.00	571,137.71	99,262.29	85.19
210204	Ажилгүйдлийн даатгал	167,600.00	134,284.50	33,315.50	80.12
210205	Эрүүл мэндийн даатгал	1,675,900.00	1,427,845.15	248,054.85	85.20
2104	Хангамж, бараа материалын зардал	6,042,700.00	6,017,200.00	25,500.00	99.58
210401	Бичиг хэрэг	2,242,700.00	2,217,200.00	25,500.00	98.86
210402	Тээвэр, шатахуун	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	774,800.00	25,200.00	96.85
210702	Дотоод албан томилолт	800,000.00	774,800.00	25,200.00	96.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,000.00	161,100.00	13,900.00	92.06
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.00	71,100.00	13,900.00	83.65
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	90,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00	1,087,761.51	12,238.49	98.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100,000.00	1,087,761.51	12,238.49	98.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,000,000.00	22,000,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,000,000.00	22,000,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,000,000.00	22,000,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,685,800.00	125,685,800.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,498,900.00	125,685,800.00	-6,186,900.00	105.18
320001	Орон нутгийн төсвөөс	119,498,900.00	125,685,800.00	-6,186,900.00	105.18
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,186,900.00	0.00	6,186,900.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,186,900.00	0.00	6,186,900.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.00	3.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,143.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Тайлант оны элэгдлийг дутуу бодуулж 1,143.0 мянган төгрөгийн элэгдлийг орхигдуулсныг аудитын явцад залруулав. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.3 дах заалт, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 3,945.5 мянган төгрөгийн зөрчил² илэрч 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага, төсөв захирагчид хариуцлага тооцох 1 албан шаардлага тус тус хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 3,345.5 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 1,414.0 мянган төгрөгөөс их, Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа Төрийн аудитын газарт ирүүлээгүйд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн тул **Хязгаарлалттай** дүгнэлт хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Хотонт сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дорждэрэмд Хурлын даргын 2023.04.26-ны өдрийн Б/04 тоот захирамжаар "Сануулах арга хэмжээ" авч сахилгын шийтгэл ногдуулж шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад Хурлын даргын 2023.12.19-ны өдрийн Б/08, 2023.12.28-ны өдрийн Б/09 тоот захирамжаар нийт 1,272,000.0 төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Цалингийн сангаас албан хаагчдад 1,600,000.0 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бус зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 190 дүгээр тушаалын 2101 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил "Ажилчдын цалин хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамаарна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Хотонт сумын ИТХ-ын тайлант жилийн цалингийн зарцуулалтыг тулган шалгахад хурлын даргад Засгийн газрын 2023.12.27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг үндэслэн үндсэн цалингийн 100 хувиар тооцож урамшуулал олгохдоо 473,493.0 төгрөгийн актыг илүү суутгаж цалин урамшууллыг дутуу олгосон байна. Энэ нь хурлын нарийн бичгийн даргын 2023.12.28-ны өдрийн Б/10 дугаар тушаалыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг дутуу олгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

5.2.3 Бараа материалын дансанд 600.0 мянган төгрөгийн принтер буюу үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.3. "Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Төсвийн шууд захирагч нь 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангаа 2024.01.26-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанаас хоцорсон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч ... **жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж**, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх, 16 дугаар зүйлийн 16.5. Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэсний 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан	1	1,143.0	1	1,143.0			1	1,143.0				
Дүн	1	1,143.0	1	1,143.0			1	1,143.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урамшуулал дутуу олгосон	1	473.5			1	473.5						
Урамшуулал илүү олгосон	1	1,272.0	1	1,272.0								
Цалингийн сангаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	1,600.0			1	1,600.0						
БМ-ийн дансанд үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	600.0			1	600.0						
СТ-аа хугацаа хоцроон ТАБ-д ирүүлсэн	1	0.0							1	0.0		
Дүн	5	3,945.5	1	1,272.0	2	2,673.5			1			